

НАЙДВАР ТЭЭСЭН ГЭМТЭН



НАЙДВАР ТЭЭСЭН ГЭМТЭН

Зохиогчийн эрх 2019.

Бүх эрх хамгаалагдсан.



“Найдвар тээсэн гэмтэн” зурагт ном нь Create International –ийн үйлчлэл болох Frontier Comic семинарт оролцсон болон багшилсан 19 уран бүтээлчийн хамтын бүтээл юм. Энэхүү бүтээлийн гол зорилго нь Есүс Христээс ирэх итгэл, найдварыг Монголчуудад түгээх явдал билээ. Бидэнтэй хамтран ажиллаж туслалцаа үзүүлсэн хүмүүс, YWAM Монгол багийнханд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Энэхүү зурагт номыг, мөн Библийн бусад материалыг дижитал хэлбэрээр авахыг хүсвэл доорх QR кодыг уншуулах эсвэл www.blessmongolia.com хуудсаар зочлоорой.





**Мэдээ ирлээ!
Мэдээ ирлээ!**

**Урвагч Хэнбишийг
ууланд бүгж байхад
нь оллоо!**


Хоёр жилийн
өмнө дайны талбараас
зугтсан тэр муу урвагч
одоо хүртэл амьд байх
нь ээ! Үнэмшихэд
бэрх юм!



Бас эцгийнхээ
гэрээс хулгай хийсэн
гэдэг биш билүү?



Тийм шүү, нүгэлт
үйлээрээ зард гарсан хүн.
Түүнийг үхтэл нь жанчиж,
шийтгэвэл таарна!



Нэгэн цагт олон сүрэг адуу малтай, нэгжээд зарц барлагтай ихэд баян хүн байжээ. Тэр баян хоёр хөвгүүнтэй юмсанж. Нэг өдөр баяны бага хөвгүүн эцэг дээрээ ирээд...



Аав аа, таныг таалал төгссөнөөс хойш надад ногдох өв хөрөнгийг одоо надад өгөөч! Та нартай амьдрах хүсэл надад үгүй. Би явж өөрийн амьдралыг эхэлмээр байна.



Чи ингэж хэлж яаж зүрхэлнэв? Хэн чамайг өсгөж, өдий зэрэгт хүргэлээ? Хэн чамайг харж, хамгаалдаг билээ? Эцэгээ хүндлэх сэтгэл чамд алга уу?



Та нарын хэн нь ч одоо надад хэрэггүй. Одооноос эхлээд би эр бие дааж амьдрах болно.






Бага хөвгүүн нь ингэж
ичгүүргүйгээр хэлэхэд эцэг нь
түүнд явахыг зөвшөөрчээ.
Тэрээр өв хөрөнгөө аваад өөрийн
гэсэн амьдралаа эхлүүлэхээр
явсан боловч, олиггүй хүмүүстэй
нийлж, хөрөнгө мөнгөө үрэн
таран хийгээд эцэст нь үгүйрэн
хоосорчээ.



Тэгээд анд нөхөд дээрээ ирж
тусламж гуйхад нь тэд түүнээс
нүүр буруулж, зандран хөөжээ.



Би юу хийчих нь
энэ вэ? Хүний гар харалгүй амьдарч
чадна гэж бодсон юмсан. Гэтэл одоо
үгээгүй хоосон, үлбэгэр дорой амьтан,
ганцаар хоцорлоо. Ингэж гутамшиг
болох ч гэж дээ.

Ийн өгүүлээд
хөвгүүн эцгээ санаж,
гэртээ байхдаа
юугаар ч дутагдаж
гачигддаггүй байснаа
харамсан боджээ.



Хэрэв би гэртээ буцаж харивал, эцэг минь үйлдсэн
хилэнцийн минь төлөө намайг алах нь зүй биз. Гэхдээ эцэг
минь ачлалт хүн. Амийг минь хэлтрүүлж,
зарцаа болгож юуны магад.

Ингээд бага хөвгүүн эцгийнхээ гэрт эргэн очиж, хийсэн буруугаа гэмшин хүлээхээр шийдэж. Харин түүнийг тааварлашгүй хувь тавилан хүлээж байлаа.

Тэр толгодоос наашаа
айсуй яваа хэн билээ? Энэ чинь
арай...Миний хүү...?!




Аав аа,
Би таны хүү
гэж дуудуулах
нэгэнт зохисгүй
хүн. Би таниас
өөрт ногдох
хөрөнгөө авч
бүгдийг нь үгүй
хийсэн. Та намайг
зарцаа болгож
аваач дээ! Би ядаж
өлбөрч үхэхгүй
шүү дээ!

Алив хүү минь, гэртээ ор. Тарган үхэр нядалж, найр
наадам хийцгээе. Хүү минь! Миний хүү эргээд ирлээ!







Есүс хүмүүст тэнгэрийн Бурханы таалалд
нийцэхээр хэрхэн залбирах ёстойг заасан.

Залбирахдаа харийнхан шиг
утгагүй хоосон үг бүү давт. Олон үг
хэлснийх нь төлөө өөрсдийг нь сонсоно
хэмээн тэд боддог юм. Тиймээс тэдэн шиг
бүү бай. Эцэг чинь та нарт юу хэрэгтэйг
гуйхаас чинь өмнө мэддэг. Тиймд
ийнхүү залбир.

Тэнгэр дэх бидний
Аав аа, Таны алдар
ариунаар дуurstугай.
Таны хаанчлал иртүгэй.
Таны таалал тэнгэрт
шигээ газарт бас
биелтүгэй.





Бидний
өдөр тутмын
хүнсийг өнөөдөр
бидэнд хайрлаач. Бид
өртөнгүүдээ уучилсан
адил Өөрсдийн минь өрийг
уучлаач. Биднийг уруу
татлагад бүү автуулаач.
Ёрын муугаас
гэтэлгээч.




Хэрэв та нар
хүмүүсийн алдааг
уучилбал тэнгэрлэг
Эцэг чинь та нарыг мөн
уучилна. Харин та нар
хүмүүсийг эс уучилбал
Эцэг чинь мөн алдааг
чинь эс уучилна.








Ээ халаг
минь, Ариг
Бөх, Хүлэгү
хоёр нааш
ир. Намайг
дуурайгаад
хий.



Та нар түүнийг
үхэхээс наагуур
жанчиж ээ! Тэр урван
тэрсэлсэн гэлээ ч
Монгол хүн! Бидний
ахан дүүс шүү дээ!







Есүс ийнхүү
өгүүлжээ.

“Нэгэн хүн нэг
хотоос нөгөө хот
руу аянд явж

“ХАЙР”



байгаад дээрэмчдийн
дунд орчихож.




Дээрэмчид түүнийг тонож, зодоод үхлүүт орхиод явжээ.



Тэр замаар явж байсан нэгэн ариун хүн түүнтэй
таараад замын нөгөө талаар мөр буруулан яваад өгч.



Отгийн ахлагч бас нэгэн хүн өнөөх хүний
хажуугаар явахдаа мөн л адил туслалгүй өнгөрөв.




Харин түүний дайсны овгийн нэгэн хүн түүгээр өнгөрч
яваад, шархтай хэвтэх өнөөх хүнийг хараад өрөвдөн энэрч,




шархыг нь боож,



тос, дарс түрхэн эмнэж өгч гэнэ.



Тэгээд өөрийн унаан дээрээ сундлан аянчны газар авчирч өгчээ.



Маргааш нь өнөөх хүн 2 зоос аянчны газрын эзэнд өгөөд



“Энэ хүнийг та харж хандаж байгаарай. Хэрвээ илүү мөнгө хэрэгтэй бол би буцахдаа төлнө” гэж захижээ”.

Есүс энэ түүхийг өгүүлээд дагалдагч нараасаа ингэж асуужээ. “Эдгээр гурван хүний аль нь дээрэмдүүлсэн хүний жинхэнэ нөхөр вэ?” гэхэд дагалдагч нар нь, “Түүнийг өршөөн нигүүлссэн хүн” гэж хариулав. Тэгэхэд нь Есүс, “Та нар ч бас ийнхүү үйлд” гэсэн юм.

"ДАГАЛДАГЧ БОЛГО"

Учир иймээс Есүсийн дагалдагч болох би бээр та нарт Түүний арга замыг зааж байгаа юм шүү дээ.

Өөрийг нь дагагч хүмүүс, бүх үндэстний ард түмнийг дагалдагч болгож, Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр баптисм хүртэж, тушаасан бүхнийг нь сахин биелүүлэхийг заах нь Есүс Эзэний таалал билээ.





"БАПТИСМ ХҮРТ"

Баптисм хүртэнэ гэж юу гэсэн үг юм бэ?


Хэрэв хэн нэгэн хүн Есүсээс өршөөл гуйвал, өөрийг нь бузарласан хир буртагаас угаагдан цэвэрлэгдсэнтэй адил хэрэг. Тэр хүн шинэ, цэвэр хүн болсон гэсэн үг. Баптисм гэдэг бол хүний дотор орших бузар булай бүхэн ариусан угаагдсаны гаднах илрэл учраас чамайг харсан хүн бүхэн нүгэлт амьдралаа орхиж, Есүст дуулгавартай амьдрах болсныг чинь мэддэг болж байгаа юм.

Байз, байз. Би үүнийг чинь хийгээгүй юм байна шүү дээ. Би тэгвэл баптисм хүртэж болох уу?

Маргааш өглөө эрт бид чамд баптисм хүртээх болно. Чи одоо амар. Есүс энэ дэлхий дээр хэрхэн амьдарсан тухай агуу түүхийг би чамд ярьж өгье.



Есүс Христ энэ орчлонд хүн болон
мэндлэхдээ Бурхан Эзэн болоод хүмүүний
хооронд гүүр тавихаар иржээ.



Бид ичгүүрт нүгэл
хилэнцийнхээ учир
ариун Бурханаас
тусгаарлагдсан
байж.

Энэ нүгэл
хилэнцийг үүрд
устган зайлуулах
учиртай юм.



Бурханы Хүү болох Есүс энэ дэлхийн бүх ичгүүр, нүглийг
Өөр дээрээ үүрч, бидний авах ёстой байсан гэсгээлийг хүртэж,
нүгэлгүй ариун хирнээ үхлийг амсжээ.




**Нүгэлт хүмүүс Өөрийг нь
загалмайд цовдолж алахыг
Есүс зөвшөөрсөн юм.**



**Түүний цус бидний төлөө урсаж, Түүний бие бидний төлөө тамлагдсан нь,
биднийг ийм аймшигт үхлээс аврахын тулд байсан билээ.**






Хэрэв чи
үнэхээр Бурханы Хүү мөн
юм бол биднийг, бас
өөрийгөө авраач!



Бид хоёр энэ
гэсгээлийг хүртэх ёстой
хүмүүс, харин энэ хүн ямар ч
нүгэл үйлдээгүй юм шүү. Есүс
ээ, Та хаанчлалдаа орохдоо
намайг санаарай!



Найз минь,
чи надтай
диваажинд
хамт байх
болно.



**Бурханы Хүү Есүс
загалмайд цовдлогдон үхсэн.**

**Гэвч үхэл түүнийг дийлээгүй.
Яагаад гэвэл үхэл амьдралыг Есүс
Өөрөө захирдаг юм.**

**Тэр бидний нүгэл хилэнцийн төлөөсийг
төлснийхөө дараа, үхлээс дахин амьдарч
мөнхөд захирагч болсон билээ.**

Ийнхүү Тэр Бурхан хүмүүс хоёрын хооронд мөнхийн гүүр тавьсан юм.

**Би одоо Бурханаас
авралыг нэгэнт олсон
тул шийтгэлээ хүртэхээс
айхгүй байна.**


**Есүсийн хажууд
цовдлогдсон хэрэгтний
адил, амиа алдсан ч
гэлээ би Есүстэй хамт
диваажинд орох болно.**

**Харин надад нэг хүсэлт байна. Хийсэн хэргийнхээ гэсгээлийг хүртэхээс
минь өмнө эцэгтэй минь уулзуулж өршөөл эрэхийг зөвшөөрөөч!**





Аав аа... Би...



Хүү минь! Эргээд
ирэхийг чинь ямар
удаан хүлээв дээ.



Би таныг
хилэгнэнэ гэж
санасан.

Чамайг
үгүйд юу
болсныг би
чамд ярьж
өгье.




Чамайг бүхнийг хаяад явсны
дараа би гүн уйтгарт автсан. Би
хүүгүй, нэр төр ч үгүй хоцорсон.
Үхэхсэн гэж хүсч байлаа.

Гэвч нэг шөнө би
зүүдэндээ тэнгэрийн
Бурхан нэгэн хаалга
нээгээд надад

“Хүүгийнхээ
төлөө санаа
бүү зов”



гэж айлдахыг
сонслоо. Тэр хаалгаар
би дээш гарч, үржил шимээр
дүүрэн үзэсгэлэнтэй хээр
тал гялалзан гялтганаж
байхыг харав.



Нэгэн хүн надтай
мэндчилээд “Намайг
дага” гэсэн. Тэр цаг
мөчөөс хойш тэр
Бурханд мөргөх
болсон.



Аав аа, би одоо өөрчлөгдсөн хүн болсон. Би таны зүүдэндээ харсан тэнгэрийн Бурханыг дагадаг болсон.



Олон түмэн минь! Өнөөдөр бүх зүйл эв зүйгээ оллоо. Хүү минь эргэн ирж, би хүүгээ хүн ёсоор хүлээж авлаа. Хотол олноороо цугларцгаа! Ядуу зүдүүс, орон гэргүйчүүдийг ч авчир! Бид найрлан цэнгэх болно!



Ээж ээ, би нэг л ойлгохгүй байна. Хэнбиш гуайг яагаад гэсгээн цээрлүүлэхгүй байгаа юм бэ?



Хэнбиш эцэгээсээ урвасан төдийгүй эх орноосоо урвасан нүгэлтэй хүн. Харин түүний эцэг хүүдээ агуу хайр энэрэлээ үзүүлж нэн сайшаалтай зүйл хийлээ.



Есүсийн тушаалуудын хамгийн агуу нь “Чи өөрийн Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч, бүх оюун ухаанаараа хайрла. Бас Чи хөршөө өөрийн адил хайрла” гэсэн тушаал юм шүү дээ.



Тиймээ, тэр гэсгээл хүртэнэ. Гэвч одоо эцэгтэйгээ эвлэрсэн тул сэтгэл амар нойрсох боллоо.





Би хулгайлан
талж, хууран урваж
амьдарсан хүн.
Гэмийнхээ гэсгээлээс
би хэрхэвч зайлж
чадахгүй.

Гэвч Есүс Христийн өршөөл, нигүүлсэлд би
мөнхөд талархах учиртай. Энэ хорвоо
дээрх амьдралаа эцэс болгож, диваажинд
Түүнтэй уулзахад би бэлхэн байна.



Хүү минь, хоёр жилийн
турш чи амь зулбаж явлаа.
Харин одоо нэр төртэйгээр
үхэлтэйгээ нүүр тулж
байгаа чинь бахархууштай.



Есүс Эзэн бас
үхэлтэйгээ нүүр
тулахын өмнө сүүлчийн
зоог барьсан билээ.

Тэр нас барахаасаа өмнө дагалдагч нартайгаа сүүлчийн удаа уулзаж байхдаа талх авч хуваагаад дагалдагч нартаа өгч “Энэ бол та нарын төлөө зориулах миний бие. Намайг санаж үүнийг үйлд”




гээд зоогийн дараа аяга авч “Энэ аяга бол миний цусаар хийх шинэ гэрээ. Та нар намайг дурсан үүнээс уугаарай” гэсэн юм. Талх идэж, дарс уухдаа та нар Есүс дахин ирэх хүртэл Түүний үхлийг тунхаглаж байгаа юм.



"ХАМТДАА ТАЛХ ХУВАА"



Есүсийн бие бидний
төлөө тамлагдан
зовж, урагдсан.



Есүсийн цус бидний
төлөө урссан.



Есүс дахин ирэх
хүртэл, эс бол бид Түүнтэй
уулзах хүртэл бидэнд өгсөн
энэ агуу бэлгийн төлөө
талархан дурсацгаая.



Тиймээ, амээн.





Энэ чинь юу
гэсэн үг билээ?



Урвагч Хэнбиш
гуай нохойн үхлээр
үхэх ёстой шүү дээ.
Гэтэл одоо...




Гарцаагүй л
үхэх нь дээ...



...гэхдээ найдвар
тээгээд одлоо доо




ЕСҮСИЙН ТУХАЙ САЙНМЭДЭЭ



Бурхан хүн төрөлхтнийг Өөртэйгээ харилцаатай байхаар бүтээжээ. Гэвч бидний гэм, нүгэл хийгээд дуулгаваргүй байдал энэ харилцааг нураасан билээ. Гэсэн хэдий ч Бүтээгч Бурхан биднийг дахин Өөртэйгээ эвлэрүүлэх замыг нээсэн юм. Тэрээр Өөрийн Хүү Есүсийг энэ дэлхийд илгээж, бүрэн дүүрэн хүн, бүрэн дүүрэн Бурхан байсан Бурханы Хүү Есүс нүглээсээ болж төлөх ёстой байсан бидний төлөөсийг төлөхийн тулд Өөрийн амиа өгсөн юм. Хаанчлалын сайнмэдээ бол Есүс бол Бурханы Хүү гэдэгт болон хүн төрөлхтний авралын төлөө хийсэн Есүсийн үйлст итгэснээр уучлагдаж, Бурханы гэр бүлийн гишүүн болоод зогсохгүй, хайрт хүүхдүүдийнх нь хувиар мөнхөд амьдрах тухай билээ. (Иохан 3:16, 17:3) Есүсийн золиосын улмаас бид үхлийн ялаас мултарч итгэлээр аврагдаж чадна. Тиймээс бид Есүсийг хайрлан, Түүнд тааламжтай амьдралыг эрэлхийлэх учиртай. Есүс хэлэхдээ “Хэрвээ та нар Намайг хайрладаг бол Миний тушаалуудыг сахих болно” гэжээ (Иохан 14:15). Есүс бидэнд олон тушаалыг өгсний дотор дараах тушаалууд нь шинэ итгэгч нарт амин чухал тушаалууд билээ.

ЕСҮСИЙН ЗААСАН 7 ЧУХАЛ ТУШААЛ



“ГЭМШИЖ,
ИТГЭГТҮН”



Есүс ирэхдээ “Бурханы Хаанчлал ойрхон байна. Гэмшиж, сайнмэдээнд итгэгтүн” гэж тунхаглаж байлаа (Марк 1: 14,15). Гэмших гэдэг нь хүн оюун бодлоо шинэчилж, нүгэлт амьдралаасаа эргэнэ гэсэн үг. Есүсийн дагалдагч Петр Есүсийг хороосон хүмүүст хандан “Гэмшигтүн, нүгэл чинь уучлагдахын тулд хүн бүр Есүс Христийн нэрээр баптисм хүрт” гэж тунхаглаж байлаа. Энэ

бол амлалттай тушаал байв. “Тэгвэл та нар Ариун Сүнсний бэлгийг хүлээн авах болно. Учир нь уг амлалт та нар болон та нарын хүүхдүүдийнх төдийгүй бас алсад байх бүгдийнх бөгөөд манай Бурхан Эзэнээр дуудагдсан болгоных билээ” (Үйлс 2:38,39). Библид “ Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл аврагдах болно” (Ром 10:9) гэсэн байдаг. Тиймээс Есүсийн өгсөн эхний тушаал бол гэмшиж, итгэн, Ариун Сүнсийг хүлээн авах юм.



“ЗАЛБИР”



Залбирах гэдэг нь Бурхантай ярилцах гэсэн үг. Есүс биднийг сэтгэл алдралгүй, байнга залбирч байхыг сануулсан (Лук 18:1-8). Есүсээс ангид бид юу ч хийж чадахгүй бөгөөд мөчир модтойгоо залгаастай бол их үр жимс гаргаж чадахын адил бид Христтэй холбоотой байж, Үгийг нь дотроо амьдруулвал юу ч гуйсан Тэрээр өгөх болно гэж айлдсан юм (Иохан 15:5-8).

“ХАЙР”



Библи дээрх тушаалуудаас хамгийн агуу нь аль болохыг нэгэн хүн Есүсээс асуусан байдаг. Тэрээр хариулахдаа “Чи Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа хайрла. Энэ бол агуу нь бөгөөд анхны тушаал мөн. Удаах нь чи хөршөө өөрийн адил хайрла. Энэ хоёр тушаал дээр бүх хууль ба эш үзүүлэгч тулгуурладаг юм” гэсэн (Матай 22:37-40). Есүс бидэнд дайснаа хүртэл хайрлаж, залбирахыг заасан билээ (Матай 6:43-48).

Есүс бидэнд өгөөмөр байхыг заасан. “Өгөгтүн, тэгвэл та нарт өгөгдөх болно. Тэгэхдээ шахагдсан, чигжсэн, бялхсан хэмжээгээр өвөр дээр чинь асгарах болно. Өөрсдийнхөө хэмжсэн хэмжээсээр та нар хариуд нь хэмжигдэх болно” (Лук 6:38) гэж Есүс айлдсан. Хэр ихийг өгөх нь чухал биш, чин сэтгэлээсээ өгөх нь чухал юм. Өчүүхэн боловч өөрт байгаагаа бүгдийг өгсөн ядуу бэлэвсэн эмэгтэйн өргөлийг Есүс магтан сайшаасан юм (Марк 12:41-44).



“ӨГӨӨМРӨӨР ӨГ”



“ХАМТДАА ТАЛХ ХУВАА”

Эзэн Есүс баригдсан шөнөө талх аваад, талархал өргөж, хуваагаад “Энэ бол та нарын төлөө зориулах Миний бие. Намайг дурсан үүнийг үйлд” гээд зоогийн дараа аяга авч, “Энэ аяга нь Миний цусаар тогтоогдох шинэ гэрээ юм. Үүнээс та нар уух болгондоо Намайг дурсаж үүнийг үйлд” гэсэн. Учир нь энэ талхыг идэж, энэ аяганаас уух бүрдээ та нар Эзэнийг иртэл Түүний үхлийг тунхагладаг юм гэж Библид өгүүлжээ (1Коринт 11:23-26). Хамтдаа талх хуваах нь бусад итгэгчдийн хамтаар хүндэтгэн мөргөхдөө Есүсийг санан дурссан зоог барих ёстойг илэрхийлж байгаа юм (Үйлс 2:42-47).

Есүс тэнгэрт одохоосоо өмнө дагалдагч нартаа ийм захирамж өгчээ. “Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн. Иймээс та нар яв, бүх үндэстнийг дагалдагч болго... та нарт тушаасан бүгдийг минь сахин биелүүлэхийг тэдэнд заа. Үеийн төгсгөл хүртэл би та нартай үргэлж хамт байх болно” (Матай 28:18-20).



“ДАГАЛДАГЧ БОЛГО”



“БАПТИСМ ХҮРТ”

Агуу Захирамж гэж нэрлэгддэг дээрх тушаалыг өгөхдөө Есүс, хүмүүсийг дагалдагч болгохдоо тэдэнд “Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр баптисм хүртээ” гэж айлдсан. Баптисм гэдэг нь Есүст итгэх болсноо хүмүүсийн өмнө гэрчлэн усанд булхахыг хэлж байгаа юм. Энэ бол дотоод итгэл үнэмшлийн гадаад илэрхийлэл бөгөөд усан дор орохдоо Христийн үхэлтэй адил хуучин амьдралаа үхүүлж, уснаас гарахдаа Христийн амилалтай адил шинэ бүтээл болж буйг билэгддэг (Ром 6:4, 2 Коринт 5:17). Эзэн Есүст итгэсэн тэр даруйдаа баптисм хүртсэн Этиопын нэгэн аялагчийн тухай Библи өгүүлдэг (Үйлс 8:26-40). Есүс Өөрөө бидэнд үлгэр дуурайлал болон усан баптисм хүртсэн билээ (Матай 3:13-17).

ДОМОГТ МОНГОЛ ХАТНЫ ТҮҮХЭН НӨЛӨӨ

ᠰᠣᠷᠬᠠᠭᠲᠠᠨᠢ ᠪᠡᠬᠢ



Сорхагтани Бэхи

Сорхагтани Бэхи хатан түүхэн дэхь онцгой нөлөө бүхий эмэгтэйчүүдийн нэг байсныг түүхчид гэрчилдэг. Персийн нэгэн түүхч “гайхалтай сод ухаантай бөгөөд дэлхийн бүх эмэгтэйчүүдээс гойд шалгарсан эмэгтэй” хэмээн хатныг шагшин магтжээ. Сорхагтани хатан Чингис хааны отгон хөвгүүн Тулуйн гэргий байжээ. Энэ номд өгүүлсэн түүх МЭ 1225 онд буюу Их хааны таалал төгсөхөөс хоёр жилийн өмнө болж буйгаар өрнөнө. Өөрт оногдсон эрх мэдлээр Сорхагтани хүү Мөнхийг 1251 онд Эзэнт гүрний хаанаар өргөмжлүүлж Тулуйн удмаас Эзэнт гүрний хаад төрөх ёстойг батлаж байв. 600–гаад оны үед Персээс эх авч Хятад улс хүртэл хүрээгээ тэлсэн зүүний Несторын загалмайн шашинтны нөлөөгөөр хатан Бэхи Христэд итгэгч болжээ. 1100 –аад оны үед Монголын хүчирхэг аймгуудын нэг байсан Хэрэйд аймаг Христийн дагалдагчид байв. Энгийн ард иргэдээ дарангуйлан захиралгүй, нигүүлсэнгүй хандаж, шашны эрх чөлөө олгохын зэрэгцээ гадны аймаг, улсуудын ёс заншил, ахуй соёлыг хүндэтгэн үздэг байсан нь ухаант хатны итгэл үнэмшилтэй салшгүй холбоотой байв. Түүний хөвгүүд Монголын Эзэнт гүрнийг ээлж дараалан хаанчилж хил хязгаарыг нь тэлж байсан юм. Сорхагтани Бэхи хатан 1252 онд таалал төгсжээ.

ᠮᠥᠨᠬᠡ



Мөнх

Мөнх хаан Эзэнт гүрний дөрөв дэхь хаан байв. Тэрээр хаан байх хугацаандаа Эзэнт гүрнийг засан тохинуулахад чухал шинэчлэлт авчирсан байна. Түүний удирдлага дор Монголчууд Ирак, Сири, Далийн хаант улсыг эзэлж байв. Мөнх хаан 1251–1259 оныг хүртэл Хархорумд засаглан захирч байлаа. Түүнийг насан эцэслэсний дараа Хубилай хаан ширээг залгамжлав. Хубилайн арми Хятад гүрний эсрэг довтлон эзэлж Их Юань гүрнийг байгуулжээ (1272–1368). Хүлэгү хаан Перс, Багдад, Ойрхи дорнодыг эзлэхээр дайтан 1253 онд Перс, Ойрхи дорнодын зарим улсыг хамруулсан Илхаант Монгол улсыг байгуулав. Тэрээр 1265 онд таалал төгсжээ. Ариг Бөх 1259 онд ах нарынхаа үгүйд хаан ширээнд суусан нь ах нартайгаа дайтахад хүргэж, улмаар 1263 онд ах Хубилайдаа бууж өгсөн юм.


ᠬᠤᠪᠢᠯᠠᠢ



Хубилай


Сорхагтани Бэхи хатны хөвгүүдийн хэн нь ч итгэл үнэмшлийг нь дагаагүй боловч Христитгэлийг хүндэтгэн үзэж, зарим тохиолдолд хөхүүлэн дэмждэг байв. Хүлэгү хаан чин сүсэгт Христитгэгч эмэгтэйг хатнаа болгож, өрлөг жанжин нь мөн адил Христитгэлт хүн байсан баримт бий. Хубилай хаан мөн ээжийгээ хүндлэх үүднээс Хятадад байх Несторын загалмайн шашинтнуудад дэмжлэг үзүүлдэг байж. Нэгэн удаа Хубилай хааны эсрэг гаргасан бослогыг дэмжсэн хэсэг загалмайн шашинтнуудыг бослого дарагдсаны дараагаар доромжлон гутаасан өөрийн тойрон хүрээлэгч зарим хүнийг Хубилай хаан зэмлэн буруушаасан гэдэг. Ингэхдээ тэр “Эсэргүү гэмтэн босогчид зүй ёсгүй аашилж байсныг Христитгэлийн Бурхан сайшаан дэмжээгүй нь лавтай. Тиймээс Христитгэлийг үүнд буруутгах нь зохисгүй хэрэг” гэжээ. Ариг Бөх Христитгэлд найр тавьдаг байсныг Францын 9–р Луис хааны бие төлөөлөгч Рубрукын Уильямын тэмдэглэлээс үзэж болно. Ариг Бөх хаан загалмайн тэмдгийг хэрэглэж, “Мессиа (Есүс) бол Бурхан гэдгийг бид мэднэ” гэж өгүүлж байсныг Уильям тэмдэглэлдээ дурдсан байна.

ᠬᠤᠯᠡᠭᠦ



Хүлэгү

ᠠᠷᠢᠭ ᠪᠥᠬᠡ



Ариг Бөх

“Найдвар тээсэн гэмтэн” номд гарч байгаа үйл явдлууд нь түүхэн үнэн болон Назарын Есүсийн тунхагласан үнэнд тулгуурлан зохиосон түүх юм.